



## НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/440

Улаанбаатар хот

### Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, Захиргааны Ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.1, 49 дүгээр зүйлийн 49.3, Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3.1, 35.3.3, 40 дүгээр зүйлийн 40.1.5, 40.1.6, Газрын төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг үйлдвэрийн бүсийн урд аж ахуйн зориулалттай 1200 м<sup>2</sup> газар эзэмшүүлсэн тус Дүүргийн Засаг даргын 2017 оны А/433 дугаар захирамжийн иргэн Соёрохын Пүрэвсүрэн (ШД68072471)-д холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.

2. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дүүргийн Газар зохион байгуулалтын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Энхтөр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.СУМЪЯАБААТАР